

*Ил-хаант улсын оюун санаа
хийгээд үзэл суртлын асуудал*

**Монголын үеийн Багдадын уналт ба сэргэлт:
Түүх болон ой санамжийн зааг³⁵⁵**

Михал Биран

Орчуулсан Д.Баярсайхан

1258 онд монголчууд Багдадыг байлдан дагуулсан явдлыг дундад зууны сүйрэл, маш хэрцгий үйлдэл хэмээхийн сацуу Аббасын Халифт улс (750-1258) мөхөж, Багдад хот унахад, Исламын соёл иргэншил бүхэлдээ доройтоход хүргэсэн гэж үздэг. “Хэрвээ монголчууд XIII зуунд Багдадын номын санг түймэрдээгүй бол, бидний арабчууд шинжлэх ухаанаар маш хол явж, атомын бөмбөг хэдийнээ бүтээчихсэн байх билээ. Багдадыг тонож дээрэмдсэн явдал биднийг олон зууны хоцрогдолд оруулав”³⁵⁶ хэмээн улиг болсон халаглалыг арабын ертөнцөд ярьсаар байна. 2003 онд Багдадыг америк цэргүүд эзлэн авах үед тэртээ Монголын байлдан дагууллын талаарх энэ

³⁵⁵ Эл өгүүлийг Европын судалгааны төсвийн хүрээнд хийсэн болно. (The research leading to these results has received funding from the European Research Council under the European Union’s Seventh Framework Program (FP/2007–13) / ERC Grant Agreement n. 312397). Энэ илтгэлийн эхний хувилбарыг Йерусалемд, 2012 оны XII сарын 9-15-нд Winter Academy-д уншсан юм. Улмаар Улаанбаатарт 2012 онд уншсан, энэ сэдвээр хоёр өгүүлэл нийтлүүлсэн: “Violence and Non-Violence in the Mongol Conquest of Baghdad” in R. Gleave and I.T. Kristo-Nagy (eds) *Legitimate and Illegitimate Violence in Islamic Thought vol. 3* (forthcoming in Edinburg University Press), 2014 оны Улаанбаатарт болсон хуралд “Libraries, Books, and Transmission of Knowledge in Ilkhanid Baghdad” илтгэлээ *Journal of the Economic and Social History of the Orient*-д 3 (forthcoming) нийтлүүлэхээр болсон юм.

³⁵⁶ Bernard Lewis, “The Mongols, the Turks and Muslim Polity,” *Transactions of the Royal Historical Society*, Fifth Series, Vol. 18 (1968): 49.

хоцрогдсон ташаарал нь зохистой зүйрлэл болж эхэлсэн.³⁵⁷ Олон зууны өмнө Багдад хот унасан тухай өгүүлэмж нь исламын хийгээд Иракийн соёлын эсрэг явуулсан буруу номтны зэрлэг үйл ажиллагаа хэмээн өнөөгийн араб уран зохиол, исламын цахим хуудсаар ихээр тархаж байна. Чингис хааны Иракаас Саддам Хусейны болон түүнээс хойших Ирак хүртэлх түүхийг тайлбарлах зорилго бүхий өрнийн зарим ерөнхий судалгааны тоймд энэ хандлага мөн илэрсээр байна.³⁵⁸

Эл өгүүлэл нь 1258 оны Багдадын уналтын асуудлыг шинэлэг байдлаар харуулах зорилготой. Ил-хаант хийгээд Мамлюкийн Султант улсуудын аль алины намтар судалгаанд болон тухайн үеийн исламын хийгээд исламын бус олон сурвалжид үндэслэн хотын сүйрэл болон түүнийг Ил-хаант улсын үед сэргээн босгож, хотын соёлт амьдрал цэцэглэсэн түүхийг харьцуулах болно. Ингэхдээ Монголын байлдан дагууллаар Аббасын Халифт улс дуусгавар болсон бол Багдад хот болон Исламын соёл иргэншил ил-хаадын үед цэцэглэсээр байсан тухай санал дэвшүүлэх юм. Монголчуудын үед Багдад хотын хувь заяаг үндсэн хоёр асуудлаар судлах болно: нэгд, байлдан дагуулал, түүний учруулсан гай гамшиг; хотын болон соёлын сэргээн босголт, ялангуяа ил-хаадын үеийн Багдадын номын сангийн сэргээн босгосон асуудлыг хөндөх болно.

Байлдан дагуулал

Багдадын байлдан дагуулал хэрцгий түрэмгийлэл байсан нь үнэн. Үүнийг монголчуудыг өмгөөлдөг хэн бүхэн хүлээн зөвшөөрдөг. Энэ эзэрхийллийн үр дүнд их хэмжээний аллага, сүйрэл, тонуул дээрэм явагдаж, дээд цэг нь Аббасын удмын халифыг хивсэнд ороож монгол морьдын хөлд дэвсүүлэн хороосон явдал юм. Гэхдээ Багдадыг зэрлэг маягаар эзлэн авсан хэрэг биш юм. Харин энэ нь нарийн

³⁵⁷ Nassima Neggaz, "The Falls of Baghdad in 1258 and 2003: A Study In Sunnī-Shī'ī Clashing Memories" (PhD diss. Georgetown University, 2013) үзнэ үү.

³⁵⁸ Raghīb al-Sargānī, *Qiṣṣat al-Tatār* (Cairo: Mu'asasat Iqra', 2006); Ahmad Maṣṣūr, *Qiṣṣat suqūṭ Baghdad*, (Beirut: al-Dār al-'Arabīyah li'l-'Ulūm: Dār Ibn Ḥazm, 2003); W. R. Polk, *Understanding Iraq: The Whole Sweep of Iraqi History, from Genghis Khan's Mongols to the Ottoman Turks to the British Mandate to the American Occupation* (New York: HarperCollins, 2005).

зохион байгуулалттай, хүчирхийллийн ажиллагаа байсан ба Хүлэгү хааны удирдлага дор чанд сахилга батыг баримталсан цэргийн үйл ажиллагаа байсан юм.³⁵⁹ Түрэмгийлэлд нэрвэгдсэн гэрчүүдийн мэдээгээр дайн бол туйлын дайн байгаагүй аж. Багдадынхны хувьд үхэл, сүйрэл нь цорын ганц сонголт байсангүй. Энэ үед хэсэг хүмүүс дагаар орохоор төлбөр төлж, ур чадвараа уралдуулж амь гарсан байдаг.

Миний судалгаанд тохиолдсон хамгийн гайхалтай гэрч нь Сафи ал-Дин Урмави (1294 нас барсан) байлаа. Тэр бээр өргөн мэдлэгтэй, хөгжимчин, дуучин, уран бичигтэн гэдгээрээ алдартай бөгөөд Аббасын халифын дотны хүн, түүний хувийн хөгжимчин, номын санч байсан ажээ. Урмави халифын хөвүүдийн багш нь байв. Байлдан дагууллын үед тэр бээр өөрийн амьдардаг хорооллын иргэдээ монголчуудаас аварч, тэр байтугай өгөөмөр тэтгэвэр авч, хожим Хүлэгүгийн засаг захиргаанд ажиллаж байжээ. Түүний түүхийг бүхлээр нь өгүүлбэл зохистой ч, хаа сайгүй түүний түүх дэлгэрэнгүйгээрээ байдаг³⁶⁰ тул би гол холбогдох асуудлын хэмжээнд хязгаарлахаар шийдлээ. Урмави дүрслэлийг сийрүүлээ:

Хүлэгү Багдадыг эзлэн аваад өөрийн жанжин нарт эрэмбэ цолынх нь дагуу хотын дүүргүүдийг дээрмийн олз хэмээн хувааж эхлэв. Энэ нь нэгээс гурван өдрийн ажил болов. Урмавигийн байсан

³⁵⁹ John Andrew Boyle, "The Death of the Last 'Abbasid Caliph: A Contemporary Muslim Account," *Journal of Semitic Studies* 6 (1961): 160- [the article brings a translation of the eye-witness account of Nasir al-Din Tusi, Hülegü's advisor, hence Boyle/Tusi]; anon. (Pseudo Ibn al-Fuwati), *Kitab al-Hawadith* (Beirut: Dar al-Gharb al-Islami, 1997): 360; and Gilli-Ellevy, "Al-Hawadit al-gāmi'a: A Contemporary Account of the Mongol Conquest of Baghdad, 656/1258," *Arabica* 58 (2011): 367; Rashid al-Din, *Jami' al-tawarikh*, ed. B. Karimi (Tehran: Iqbāl, 1338/1960), 2: 713; Wheeler M. Thackston, trans., *Jami' u't-tawarikh [sic] Compendium of Chronicles* (Cambridge MA: Department of Near Eastern Languages and Civilizations, Harvard University, 1998-1999), III: 498; Shihab al-Din Ahmad b. 'Abd al-Wahhab al-Nuwayri, *Nihayat al-arab fi funūn al-adab* (Cairo: al-Hay'a al-Miṣriyya al-'amma li'l-Kitab, 1984), 23: 234; Waṣṣaf, *Ta'rikh-i Wassaf (Tajziyat al-amsar wa-tajziyat al-a-mar)*. Bombay, 1269/1852–1853 (rpt. Tehran, 1338/1959–1960), 43; and 'A. M. Ayati, *Tahrir-i ta'rikh-i Wassaf* (Tehran: Chāpkhānah-i 'ilmī, 1346/1967), 23.

³⁶⁰ Biran, M. "Music in the Conquest of Baghdad: Safi al-Din Urmawi and the Ilkhanid Circle of Musicians," in *The Mongols and the Transformation of the Middle East*, ed. De Nicola, Bruno and Charles Mellville (Leiden: E.J. Brill, 2016), 131-154; the text appears in Shihab al-Din al-'Umari, *Masalik al-absar wa-mamalik al-amsar* (Beirut: Dar al-kutub al-'lmiyya, 2010), 10: 353-356.

хороолол оногдсон жанжин дүүргийн хаалгыг цохиж “хаалгаа нээ, дагаар ор, бид та нарт *аман* буюу аюулгүйн батламж өгнө. Биднийг дагахгүй бол хаалгыг шатааж та нарыг ална” хэмээжээ.

Монголчууд аюулгүйн батламжаа тодорхой мөнгөөр зардаг тухай сүүлд өгүүлэх болно. Урмави энэ дуудлагыг хүлээн авч Багдадын хамгийн сайн дуучдыг авчран монгол жанжин, түүний цэргүүдийг харамгүй зугацуулж эхлэв. Түүний авьяас монголчуудыг гайхашруулж, тэд түүнийг Хүлэгү рүү илгээв. Тэд айсан Урмавид “хаан чамд ямар ч хор хөнөөл учруулахгүй, Хүлэгү авьяастай хүнийг их ойшоодог” хэмээн явуулав. Байгаа гоёлоо өмсөж, алтадсан болон мөнгөн тавагтай тансаг хоол хүнс, дарсыг зэхэж, хөршүүдээсээ цуглуулсан бэлэг сэлтийн хамт аван Хүлэгүгийн гэрт очив. Түүнтэй бусад дуучид хамт явав. Ил-хаан Урмавигийн тоглолтыг үзээд ихэд таалж, түүнд Халифын ордонд авч байснаас хоёр дахин их тэтгэмж, дээр нь халифын цэцэрлэгийг олгож, сүүлдээ Ил-хаант улсын засагт ажиллах алба хайрласан байна. Үүгээр үл барам, гэртээ харьж хорооллоо хамгаал гэжээ. Ийнхүү түүний амьдарч байсан дүүрэг сүйрэлд өртөөгүй юм.

Ялагдсан хүн амд “төлбөрөө төл эс бол үх” гэдэг санал ийм шулуун хэллэгээр Багдадын байлдан дагуулын түүхнээ ховор тохиодог. Хүлэгүгээс өөр хүмүүс *аман* буюу аюулгүйн батламжийг нэлээд ахиу мөнгө төлж авсан мэдээ байдаг. Дэлгэрэнгүй мэдээ сурвалж болгонд адил биш ч ихэнх тохиолдолд *аман*-ыг Багдад хотын христ, еврей, Багдад орчмын *Нилла* хотын *шуа* хүмүүс, Хорасаны наймаачид (монголчуудтай эртнээс харилцаанд орсон), зарим мусульман дээдэст олгосон байдаг.³⁶¹ Эдний дундаас *шуа*

³⁶¹ Жиншээ нь, *Kitab al-Hawadith*, 359, 360; Hend Gilli-Elwewy, “Al-Hawadith,” 367, 368; Tusi/Boyle, “Death,” 159. Tusi/Boyle-ийн үзэж байгаагаар, эрдэмтэн, шейх хийгээд монголчуудад эсэргүүцэл үзүүлээгүй хэн болгонд *аман* өгдөг байжээ. Энэ нь байлдан дагууллын эхэн үеэс хэрэгжиж байсан гэж тэр бээр үзжээ. Бар Хэвразусын мэдээгээр христ шашинтнууд амь аврагдсан байна, Bar Hebraeus, *The Chronography of Gregory Abu'l-Faraj. . . commonly known as Bar Hebraeus*, translated by E. A. W. Budge (Rpt. London: The Georgian Press, 2003): 1: 431. Түүний араб хувилбарыг баримталбал, христ, *шуа* хүмүүс болон эрдэмтэд цаазын тавцнаас амь аврагдаж байжээ, Ibn al-Ibri, *Tarikh Muhtasar al-Duwal* (Beirut: Dar al-Mashriq, 1992): 271. Ибн Катир еврей хүмүүс мөн адил аврагдсан хэмээжээ, Ibn Kathir, *al-Bidaya wa-l-nihaya* (Beirut: Dar ihya' al-turath al-'arabi, 1993): 13: 235.

хүмүүс болон наймаачид өөрсдийн амийг их үнээр аварсан нь ойлгомжтой.³⁶²

Урмавитай адил “авьяас” бүхий хүмүүс аюулгүйн батламж авсан хийгээд албанд орсон өөр жишээ олон бий. Дурдвал, Фалак ал-Дин Мохаммад Сайф ал-Дин Айдамир ал-Муста’сими (1240-1310) бөгөөд Аббасын халифын цэргийн гарамгай жанжин, бичгийн хүн бөгөөд уран бичлэг, захидал харилцаа, морин уралдааны шинжээч гэдгээрээ нэрд гарчээ. Үүнээс гадна түүний гоо үзэсгэлэн нь олноо алдаршжээ. Багдадыг эзэлсний дараа түүнийг Гүржийн хаантай (*Malik al-Kurj*) хамт байсан гэсэн мэдээ байна. Магадгүй Хүлэгүгийн армийн Гүрж нэгтгэлийн жанжны хамт байсан байж болох юм. Улмаар түүнийг Хүлэгүд авчирч, монгол хаан түүнийг “*hukama* буюу мэргэдийн даргаар (*shihna*) томилжээ. Тэр бээр Хүлэгүгийн ордонд хоргодон үлдэж ихэд таашаагджээ.”³⁶³

Энэ явдал Урмавигийн хэрэгтэй төстэй, албат хүн мэдлэг чадлаараа орон нутгийн жанждын анхааралд өртөж улмаар Хүлэгүгийн таалалд нийцэж Ил-хаант улсад алба хаших болсон байна. Энд төлбөрийн асуудал дурдагдаагүй боловч энэ нь хэрэг явдлын нэгэн хэсэг байсан байх. Энд мэргэдийн тухай гарч байгаа нь Рашид ал-Дины мэдээтэй дүйж байна: “Хүлэгү мэргэн сэцнийг ихээр таашаадаг ба мэдлэгтэй хүмүүсийг шинжлэх ухааны үндсэн салбараар маргахыг ихэд урамшуулдаг, тэтгэлэг цалингаар шагнадаг байв. Түүний ордон эрдэмтэн мэргэдээр (*‘ulama’ wa hukama*) дүүрэн байв.”³⁶⁴

³⁶² Шиа хүмүүсийн тухай *Kitab al-Hawadith*, 360; Gilli-Elewy, "Hawadit", 368; and Ibn Tāwūs, *Iqbāl al-a'māl* (Beirut: Manshūrāt mu'asasat al-a'lamī li'l-maṭbū'āt, 1996): 65, 67. Худалдаачдаас авч байсан төлбөрийн тухайд, Ibn Kathir, *al-Bidaya*, 13: 235.

³⁶³ Ibn al-Fuwati, *Talkhis majma' al-udaba* (Tehran: Mu'asasat al-tibā'a wa-l-nashr, 1995): 3:281, намтар 2638.

³⁶⁴ Rashīd/Karīmī, 2:734 and Rashīd/Thackston, 2: 513 (*‘ulamā’ wa hukamā’* гэсэн нь “философчид ба эрдэмтэд” гэж орчуулагдана); Reuven Amitai, “Im Westen nicht Neues? Re-examining Hülegü’s offensive into the Jazira and Northern Syria in Light of Recent Research,” in *Historicizing the Beyond: The Mongolian Invasion as a New Dimension of Violence?* ed. F.Krämer, K.Schmidt and J.Singer (Heidelberg: Universitätsverlag Winter, 2011): 83-96.

Өөр нэг жишээ бол, Багдад хотын уран бичээч, Урмавигийн шавь Яагут ал Муста'сими, мамлюк хүн боловч Аббасын халифын ойрын хүн байжээ. Байлдан дагуулал эхлэхэд Яагут монголчуудаас зугтан сүмийн өндөр цамхагт хоргодож байжээ. Баригдахын даваан дээр тэр бээр нэгэн даавуун дээр хэдэн үг маш гоёмсоор бичжээ.³⁶⁵ Дараагаар чухам юу болсныг бид мэдэхгүй ч Яагут ил-хаадын үед их идэвхтэй ажиллагаа явуулж алдар нэрээ олжээ. Тэр бээр Абага ил-хааны үед Урмавигийн зэрэгцээ шилдэг эрдэмтдийн нэгд тооцогдож байжээ.³⁶⁶

Үүгээр бид Аббасын ордны ойрын гурван мусульман хүн Хүлэгү хааны ивээлд орсныг мэдлээ. Бусад Багдадын алдартай хүмүүс мөн адил энэ ивээлийг олжээ. Ибн ал-‘Алгами нь Халифт улсын сайд байсан ба байлдан дагууллын үед Хүлэгүгийн талд орж улмаар энэ үүргээ үргэлжлүүлэн хийжээ (харамсалтай нь хэдэн сарын дараа таалал төгсжээ). Ибн Дарнус болон халифын *sahib al-diwan* буюу сангийн их сайд Фахр ал-Дин ал-Дамгани хоёулаа Хүлэгү рүү халифаас томилогдсон элч нар байжээ. Хүлэгү дайны дараа нэгийг нь урчуудын даргаар, нөгөөг сангийн сайдаар эгүүлэн томилжээ.³⁶⁷

Үүнээс өөр нэг жишээ нь, Багдад хотын исламын шүүгч (*qadi al-qudah*) ал-Банданижийг 1257 онд Аббасын Халиф энэ албанд томилжээ. Багдад унасны дараа Хүлэгүтэй уулзахаар очоод албан ажилдаа эгүүлэн томилогдож 1269 онд нас бартлаа Хүлэгүгийн дээд шүүгчийн албанд зүтгэжээ.³⁶⁸ Эдгээрээс үзэхэд монголчууд Исламын соёл иргэншил рүү дайрсан дүр зураг гарч ирэхгүй байна. Харин ч Хүлэгү дагаар ороогүй халифын зөрүүд зангийн золиосонд

³⁶⁵ Vladimir Minorsky, trans. *Calligraphers and Painters, A Treatise by Qādī Aḥmad, son of Mīr-Munshī, circa A.H. 1015/A.D. 1606*, (Washington: The Smithsonian Institution, 1959): 57-60.

³⁶⁶ Yāqūt-ын тухай 'Umari, 10: 348; Shams al-Din Muhammad b. Ahmad al-Dhahabi, *Ta'rikh al-Islam* (Beirut: Dar al-kitab al-'arabi, 2003), 60: 373-4; Muhammad b. Shakir al-Kutubi, *Fawat al-wafayat* (Beirut: Dar al-kutub al-'ilmiyya, 2000), 2: 592-3; Sheila R. Canby, "Yāqūt al-Musta'shimī," *Encyclopaedia of Islam, Second Edition*. EI 2 Online.

³⁶⁷ Gilli-Halevy, "Hawadit," 369; Boyle/Tusi, "Death," 160.

³⁶⁸ Ibn al-Fuwati, *Talkhis*, 1:87; *Kitab al-Hawadith*, 361; Rashīd/Karīmī, 1:714; Rashīd Thackston, 2:499.

хотыг цээрлүүлэхийн оронд хотын тогтвортой байдлыг сахих бүхий л арга хэмжээг авч байжээ. Хааны нэр төрийг дээшлүүлэх арга замыг хайж Аббасын алдар гавьяаны гол төлөөлөгчдийг ордондоо ажиллуулж байжээ.

Багдадыг эзлэх үед Исламын эсрэг үйл ажиллагаа явуулж байсан гэдэгт эргэлзэх өөр нэгэн шалтгаан нь ихэвчлэн *сунни* итгэлтэй мусульманчууд Хүлэгү хааны армид цөөнгүй байжээ. Шинээр олдсон ба саяхан нийтлэгдсэн зохиогч нь үл мэдэгдэх сурвалж үүнийг нотолж байна. Өргөн мэдлэгтэй эрдэмтэн Кутб ал-Дин Ширазигийн (1323 онд нас барсан) бүтээл гэж эндүүрч байсан энэхүү сурвалжид Хүлэгүгийн армид Туркестан, Трансоксын цэргийн нэгтгэл, Фарсын атабекууд, Рүмийн султад (Анатоли), Хорасан, Систан, Мазандаран, Кирман, Рутамдар, Ширван, Гүристан, Ирак, Азербайжан, Арран болон Луристаны ноёд вангууд оролцсон хэмээжээ.³⁶⁹ Эдгээр нь монголчуудын байлдан дагуулсан газрууд байсан ба Гүржийнхнээс бусад нь мусульманчууд байснаас үзэхэд Хүлэгүгийн армид исламын төлөөлөл ихэнх нь байсан байна.

Энэ сэдэвт холбогдуулан ал-Умаригийн Ил-хаант улсын түүхэд холбогдох хэсгийг авч үзье. Умари нь (1349 онд нас барсан) Мамлюк түшмэл хийгээд бүх талын өргөн мэдлэгтэй хүн байв. Мамлюк түүхчдээс монголчуудын тухай хамгийн их мэдлэгтэй нь Умари байжээ (Урмавигийн түүх мөн түүнээс ашигласан байдаг). Иранд ирсэн монголчууд персүүдтэй гэрлэн (*a`ajim*), перс соёлд уусаж улмаар тэд “халиф хийгээд орон нутгийн ёсоор үйл ажиллагаагаа явуулж, өөрсдийн монгол ёсыг хойш тавьжээ” хэмээн цааш нь:

Хүлэгү Багдадыг байлдан дагуулахад анхнаасаа бүх зүйлийг байсан байранд нь хадгалах бодолтой байжээ [өөрөөр хэлбэл хотыг нурааж сүйтгэхгүй]. Гэхдээ түүнтэй ирсэн монголчууд түрэмгийлэл (*shidda*) үйлдэж, хүмүүс тэднээс ухаангүй айж байсны (*ifrat takhawwuf*) улмаас үүнийгээ гүйцэлдүүлж

³⁶⁹ Anon [pseudo Qutb al-Din Shirazi], *Akhbār-i Mughūlān* (Qum: Kitabkhanah-i buzurg-i hazrat-i ayatallah al-'uzma Mar'ashi Najafi, 2010): 23-4.

чадсангүй. Тэд Хүлэгүгээс эмээдэг байсан тул түүнтэй уулзахгүй байхыг эрмэлзжээ. Харин Хүлэгү тэдний газар нутгийг сүйрүүлэхийн оронд дуулгавартай байж, татвар төлбөр авахыг итгүүлэхийг оролджээ. Гэсэн хэдий ч хувь заяаны шийдвэрийг өөрчлөх боломжгүй юм.³⁷⁰

Үнэхээр, Хүлэгүтэй уулзсан хүмүүс ихэнхдээ өөрсдийн амь хийгээд албан тушаалаа хадгалж чаджээ. Сурвалжийн сүүлийн өгүүлбэр их чухал утгыг агуулдаг. Тухайн цаг үеийн хүмүүс Монголын байлдан дагуулалд хэрхэн хандаж байсныг тодруулж байна: энэ бол “хувь заяаны шийдвэр” буюу бурханы хүсэл байжээ. Иймээс монголчуудын түрэмгийлэл нь үзэн ядалт төрүүлэвч эзэрхийлэгчдийн нийтлэг эрх мэдэл хэмээн харагдаж байжээ. Айдаст автагдсан Багдадын дээдэс хамгаалахын оронд хууль ёсны хүчирхийлэл хэмээн хувь заяандаа найджээ. Энэ үзлээр Абу Шама (1268 нас барсан), Туси (1274 онд нас барсан) ал-Казарини (1298 нас барсан)³⁷¹ нарын байлдан дагууллыг дүрсэлсэн эхэн үеийн бүтээлийн хандлагыг тайлбарлаж болох юм. (Эдний хожуу үеийн бүтээл нь илүү нарийн болсон байдаг). Монголчууд мэдээж энэ үзлийг хүлээн авч халиф хийгээд ислам, христийн хаадад бичсэн захидалдаа “ бид бурханы цээрлэл” гэж Багдадаас өмнө болон хойно өөрсдийгөө нэрлэх болжээ.³⁷²

³⁷⁰ Umari, *Masalik*, ed. and trans, K. Lech as *Das Mongolische Weltreich: al-Umari's Darstellung der mongolischen Reiche in seinem Werk Masalik al-absar fi mamalik al-amsar*, Asiatische Forschungen, vol. 14. (Wiesbaden, 1968):102.

³⁷¹ Abū Shāma, *Tarajim rijal al-qarnayn al-sadis wa al-sabi' al-ma'ruf bil-dhail 'ala al-rawdatayn*, ed. M. Kawtharī (Cairo: Maktab nashr al-thaqafa al-islamiyya, 1947): 198; Kāzarūnī, *Mukhtaṣar al-ta'rīkh, min awwal al-zamān ilā muntahā dawlat Banī al-'Abbās* (Baghdad: Mudiriyyat al-thaqafa al-'amma, 1970): 270ff; Boyle/Tūsī, 151-61, and Juwaynī/Qazwīnī, vol.3: 283-92; Cf. S. Conermann, 'Die Einnahme Bagdads durch die Mongolen im Jahre 1258: Zerstörung – Rezeption – Wiederaufbau,' in *Städte aus Trümmern. Katastrophenbewältigung zwischen Antike und Moderne*, eds A. Ranft and A. Selzer (Göttingen: Vandenhoeck & Ruprecht, 2004): 54-100; F. Krämer, 'The Fall of Baghdad in 1258: The Mongol Conquest and Warfare as an Example of Violence,' in *Historicizing the "Beyond": The Mongolian Invasion as a New Dimension of Violence?*, edited by F. Krämer, K. Schmidt and J. Singer (Heidelberg: Universitätsverlag WINTER, 2011): 97-116.

³⁷² R.Amitai-Preiss, *Mongols and Mamluks: The Mamluk-Īlkhānid War, 1260–1281* (Cambridge, UK; New York: Cambridge University Press, 1995): 22-4; W. Brinner, 'Some Ayyūbid and Mamlūk Documents from Non-archival Sources,' *Israel Oriental Studies* 2 (1972): 127-136; P. Meyvaert, "An Unknown Letter of Hulagu, Il-Khan of Persia, to King Louis IX of France," *Viator* 11 (1980): 245-59.

Сэргээн босголт

Монголчууд исламд орсноос хойш буюу бурханы байдал илүү тод болж тэдний түрэмгийллийг хуульчлан хүлээн авах нь амар болсон байх. Гэхдээ миний үзэж байгаагаар, энэ нь хотыг түргэн хугацаанд сэргээсэн явдалтай илүү холбогдоно. Үүнтэй уялдуулан Иракийн анхны даргач Имад ал-Дин Газвинигийн намтраас эшилмээр байна. Түүний намтар Ибн ал-Фуватигийн намтрын толь бичигт (*Talkhis majma` al-udaba*) байдаг. Ибн ал-Фувати нь (1323 онд нас барсан) Багдадын сүйрлийг нүдээр үзсэн ба хамаатнуудынхаа хамт монголчуудад баривчлагдаж байжээ. Хэдэн жилийн дараа Насир ал-Дин Тусигийн ачаар суллагдаж Марагад иржээ. Марага хотын одон орон судлалын төвийн номын санчаар ажиллаж байгаад 1280-1281 онд Багдадад буцаж ирж, 20 гаруй жил Мустансирия (Mustansiriyya) шашны коллежийн номын санчаар ажиллажээ.³⁷³ Тэр бээр Имад ал-Дины тухай ийнхүү өгүүлжээ:

“Бурхан өөрийн чадвар болон шийдвэрээр халифыг хөнөөж, Багдад сүйрч, төв масчид сүм галдан шатаагдаж, бурханы газар хоосорч байх тэр үед Аллах нигүүлслээ үзүүлж Имад ал-Диныг томилуулав. Тэр бээр [Багдадад] ирж сүм, сургууль барьж, бунхан болон асрамж, буяны газруудыг сэргээв. Хандиваар эрдэмтдэд, хуульч, *суфи* нарт цалин өгч, исламын алдар энхийн хотод эргэн ирэв.”³⁷⁴

Энд халифын үхэл хийгээд Багдадын сүйрлийг Хүлэгү болон монголчуудаас болсон гэж үзээгүй, харин бурханд тохсон байна. Үүний зэрэгцээ, Имад ал-Дин Газвини, их нэр хүндийг олон 1262 онд буюу Багдад унасны 4 жилийн дараа нас эцэслэжээ. Ибн ал-Фуватигийн үзэж байгаагаар энэ 4 жил Багдад хотыг шашны хуучин алдар цуунд хүргэн сэргээн босгоход хангалттай байжээ. Хотын сүйрэл хийгээд аллагын хэмжээ болон сүйрлийн үргэлжилсэн

³⁷³ Ibn al-Fuwaṭī тухай F. Rosenthal, ‘Ibn al-Fuwaṭī’ in *EI* 2; Devin DeWeese, “Cultural Transmission and Exchange in the Mongol Empire: Notes from the Biographical Dictionary of Ibn al-Fuwaṭī,” in *Beyond the Legacy of Genghis Khan*, ed. Linda Komaroff (Leiden: Brill, 2006):11-29.

³⁷⁴ Ibn al-Fuwaṭī, *Talkhis*, 2:125-6, намтар 1169.

хугацааг цохон тэмдэглэсэн өөр эсрэг талын сурвалжийн мэдээ олж болох боловч, энд Ибн ал-Фуватигийн хувилбарыг хүлээн зөвшөөрмөөр байна. Учир нь тэр бээр гарцаагүй Ил-хаант улсын Багдад хотын эрх мэдэлтнүүдийн хамгийн мэдлэгтэй хүмүүсийн нэг байсан. Ил-хаадын үеийн Багдад хотын соёлын амьдралыг нэхэн сурвалжилж байгаа миний сүүлийн үеийн ажилд Ибн ал-Фуватигийн мэдээтэй ижил төстэй баримтууд байна (сэргээн босголтын талаар арай хэтрүүлсэн талтай ч гэсэн). Эдгээр нь үйл явдал болсон газраас хамаагүй хол байсан хүмүүсийн бичсэнчлэн адил хот хоосрон сүйрсэн хэмээх гунигт эмгэнэлтэй нийцэхгүй байна.

Үнэхээр хотыг эзлэн авсны дараа хотын сэргээн босголт эхэлсэн гэж сурвалжууд нотолж байна: 1258 онд Сирийг орхин явахдаа Хүлэгү хотыг дахин барьж зах зээлийн газрыг нээх зарлиг буулгажээ. Тэр бээр 3000 цэргийн нэгтгэлийг хотын сэргээн босгох ажилд томилохдоо юуны түрүүнд шарилыг булж, хог хаягдлыг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээнд тосгоны ардаас татвар татаж, гамшгийн үлдэгдлийг зайлуулахад зарцуулахыг шаарджээ.³⁷⁵ Сэргээлтийн ажилд монголчуудын томилсон Имам ал-Дин, түүний гол өрсөлдөгч 1259-1283 онд Багдадын даргач байсан Ала ал-Дин Жувейни нар их үүрэг гүйцэтгэж, хотод олон эерэг зүйлсийг авчирчээ.

Багдадын сурвалжид Хүлэгүгийн залгамжлагч ил-хаан Абагаг “шударга хаан ба хот барилгын ажлыг өндрөөр үнэлдэг”³⁷⁶ хэмээсэн нь орон нутгийн түшмэдээс гадна ард олон сэргээн босгох үйл ажиллагаанд монголчуудын үүргийн тухай мэддэг байсныг гэрчилж байна. Үнэхээр, хотын гол гол сүм хийд, сургуулиуд цөөн жилийн дотор амжилттай сэргээгдэж, тухайлбал хотын захын хороолол дахь Муса Казимийн масчид сүм сэргээн засварлагдсаныхаа дараа ихэд цэцэглэх болж XIV зууны дунд үед жижиг хотын төв болтлоо

³⁷⁵ Boyle/Tusi, “Death,” 161; *Kitab al-Hawadith*, 361-362; Robert P. Blake and Richard N. Frye, *History of the Nation of the Archers (The Mongols)* by Grigor of Akanc’ энд Malak’ia The Monk: The Armenian Text Edited with an English Translation and Notes, *Harvard Journal of Asiatic Studies*, 12 (1949): 345.

³⁷⁶ *Kitāb al-Hawādith*, 453.

хөгжжээ. Мустансирия болон Низамиягийн гол *мадраса*-сургууль нь байлдан дагууллаас хойш нэг жил хагасын дараа дахин нээгдсэн байна.³⁷⁷

Усжуулалтын асуудлыг орхигдуулж болохгүй, учир нь монголчуудын талаарх өөр нэгэн домог Иракийн усан сувгийн системийг нурааж газар орныг ядууралд хүргэсэн гэх яриагай холбоотой. Багдадыг эзлэх явцад хойд усан хангамжийн нэг суваг эвдэрсэн мэдээ сурвалжуудад байна. 1270-аад онд Жувейни, 1290-ээд онд Газан ил-хаан Багдадын дотоод дүүргүүдэд шинэ усан суваг барих ажилд маш их хөрөнгө оруулж тэр нь их амжилтад хүрсэн байдаг. Жувейни сургуулийн байгууллагуудын дэргэд үерийн далан байгуулсан байна. XIV зууны дунд үед Багдад хотын усжуулалтын систем хийгээд хотын захаар цэцэглэн хөгжиж байгаа газар тариаланг харсан түүхч, газар зүйч Мустафи Газвини машид биширсэн байдаг.³⁷⁸

Монголчуудын болон тэдний түшмэдийн санхүүжилтээр боссон барилгын ажлаас гадна хувийн, албаны болон тухайн нутгийн бус хүмүүсийн санаачилгаар олон зүйлийн барилга боссон байна: Рашид ал-Дины бариулсан Газания коллеж, 1271 онд сүүлийн Аббасын халифын хүүгийн бэлэвсэн эхнэр, хожим Жувейнигийн эхнэр болсон эмэгтэй Исматия коллеж болон өөрийн бунхны барилга, 1270-аад оноос эхлэн зарим “доод” зиндааны хүмүүс буюу наймаачид, эрдэмтдийн бариулсан *dar al-qurans* буюу Коран судар унших газрууд, *ribats* буюу асрамжийн газруудыг нэрлэж болно. Үүнээс Багдадын хүн ам харьцангуй чинээлэг байсан хийгээд хотын эрдэм номын ажил цэцэглэж байсныг харж болно.

Сэргээн босгох ажилд байлдан дагууллаас өмнөх олон жилийн (1243, 1248, 1253, 1255, хамгийн хор хөнөөлтэй нь 1256 онд

³⁷⁷ *Kitab al-Hawadith*, 376; Hend Gilli-Elewy, *Bagdad nach dem Sturz des Kalifats. Die Geschichte einer Provinz unter ilhanischer Herrschaft* (Berlin: Klaus Schwarz, 2000): 33.

³⁷⁸ Hamdallah Mustawfi, *Nuzhat al-qulub*, edited and translated Guy le Strange, (Leiden: Brill and London: Luzac, 1915, 1919): 40-41; Rashid Wu Painan, “The fall of Baghdad and the Mongol rule in al-Iraq, 1258-1335,” (Phd diss., University of Utah, 1974).

болсон) үерийн гамшигт нэрвэгдсэн хороолол, дүүргүүдийг сэргээн засварлах ажил оржээ. Өөрөөр хэлбэл, монголчуудаас өмнөх үеийн хотын байдлыг сайжруулсан гэсэн үг. Газан ил-хааны үед (1295-1304) Багдад хот цэцэглэн халифын үеийн хэмжээнд хүрсэн гэдгийг мамлюк түүхчид хүртэл хүлээн зөвшөөрчээ. Өлзийт ил-хааны үед (1304-1316) Багдадыг “газар дээрх диваажин” хэмээдэг байв.³⁷⁹

Сэргээн босголтын ажил хоёр үр дагавартай: нэгд, Ил-хаант улсын Багдад хот өмнө дурдсан үерээс гадна, 1278, 1284 болон 1325 оны үерт авгаж байсан боловч орон нутгийн удирдлага байдлыг хянаж чадсан байна.³⁸⁰ Хоёрт, Багдад хот болон түүний орчин тойрон бэлчээрийн хийгээд ан авын арвин газраараа алдартай байсан. Иймд тухайн нутаг ил-хаадын өвөлжөө болсон байна. Энэ нь Иранд төвлөрч байсан ил-хаад, ялангуяа Газан хаанаас хойш, Багдадад хоёр жилд нэг болон түүнээс олон удаа, тухайлбал Өлзийт хаан 12 жилд 7 удаа ирж байсан бөгөөд монгол хаад өөрсдийн нүүдлийн ордтойгоо буюу гэр бүл, түшмэд, худалдаачид, эрдэмтдийн хамт морилж байжээ.³⁸¹ Багдад-Табриз-Марага чиглэлийн зам, өөрөөр хэлбэл, Иракаас Ил-хаант улсын нийслэл хийгээд тэдний зуслангийн газар хүрэх маршрут нь мэдлэг түгэх үндсэн зам болсон байна.

Барилга байгууламжийн сацуу хотын оюуны амьдрал түргэн хугацаанд сэргэж эхлэв. Энд номын сангийн жишээг авъя. Учир нь монголчууд Багдадын номын санг шатааж, Тигр мөрөн номын хар бэхээр угаагдсан гэх хүчтэй дүрслэл Багдадын уналттай холбогдон яригддаг. Үнэн хэрэгтээ энэ тухай сурвалжийн мэдээ огт байдаггүй.³⁸² Монголын байлдан дагуулал, түүний үр дагавар болох хот тосгодын дээрэм тонуул Багдад хотын номын санд хор учруулсан нь мэдээж. Энэ нь гал түймэр, үер, үймээн, ерөнхий эмх замбараагүй байдлаас

³⁷⁹ Ibn al-Fuwati, *Talkhis*, 2:433

³⁸⁰ *Kitab al-Hawadith*, 431, 477; Dhahabi, *Ta'rikh al-Islam*, 61:235-6.

³⁸¹ Өлзийт хааны айчлалын тухай Charles P. Mellville, “The Itineraries of Sultan *Oljeitu*, 1304–16,” *Iran* 28 (1990): 55–70; Abu Sa'id ил-хааны ордын нүүдлийн тухай Ibn Battuta, *The Travels of Ibn Battuta*, tr. H. A. R. Gibb (Cambridge: The Hakluyt Society, 1958), 2: 342-344.

³⁸² Энэ хэсэг М. Biran, “Libraries, Books, and Transmission of Knowledge in Ilkhanid Baghdad,” forthcoming in *Journal of the Economic and Social History of the Orient*-д бий.

болсон. Өөрөөр хэлбэл, шууд бус үр дагавар юм. Юуны өмнө Багдад хотынхон амь зуухын тулд бусад үнэт зүйлсийн хамт номоо зарж эхэлсэн. Энэ үед Ирак хийгээд бусад газрын номын худалдаачид үүнээс ашиг олохоор яаравчлав.³⁸³ Хамгийн чухал нь монголчууд халифын ордонд байсан номын сангийн ихэнх номыг Насир ал-Тусигийн төлөөлөгчид бүртгэлд оруулан Ил-хаант улсын оюуны шинэ төв болсон Азербайджан руу нүүлгэв.³⁸⁴ Хэдий тийм боловч Аббасын болон Ил-хаант улсын Багдад хотын гол номын сангууд байлдан дагууллаас жил хагасын дараа үүдээ нээв. Мустансирия шашны коллежийн номын сан дайнд их нэрвэгдсэн ч сэргээгдэж тэнд ажиллаж байсан хүмүүсийн зарим нь ажилдаа эргэж ирэв.³⁸⁵ Сүйтгэгдсэн гар бичмэлийг сэргээж, дамын наймаачдын гараар орсон номыг эргүүлэн авч, Багдадаас гадна байсан ном худалдан авах замаар номын сангийн хөмрөг илүү их баяжсан байна. XIII зууны эцэст номын сан хуучин нэр алдраа олж, 400.000 номтой Марага хотын одон орон судлалын номын сангийн дайнд очсон байна.³⁸⁶

Ал-Макризи эл номын санд Чингис хааны “Их засаг” хууль байсан³⁸⁷ гэж үзсэн нь магадгүй худлаа байх, гэхдээ сан хөмрөгт нь ховор ном их байсан, тухайлбал анагаах болон бусад шинжлэх ухааны номоороо 1296 онд Газан хааныг гайхашруулжээ. Номын сан хэн бүхэнд нээлттэй, ил-хаадын ордтой хамт ирсэн эрдэмтэд эндээс ном судраа уншиж, оюуны их өвөөр бахархаж байжээ. Нэгэн мэргэн “Марага хотод эхнэр гэр бүлтэй байгаагүй бол Багдадад суурьших

³⁸³ *Kitab al-Hawadith*, 361; for selling books in times of crisis see also Dhahabi, *Tarikh*, 54:80-81; 61:192.

³⁸⁴ Dhahabi, *Ta'rikh*, 58:113-15; Umari, *Masalik*, 9:114; J. A. Boyle, “The Longer Introduction to the *Zij-i Ilkhani* of Nasir ad-Din Tusi,” *Journal of Semitic Studies* 8 (1963): 246-7; Ibn al-Kathir, *al-Bidaya*, 15:341-2.

³⁸⁵ *Kitab al-Hawadith*, 376; Ажиллагсад хийгээд лааны суурийн талаар Najī Maʿrūf, *Tarikh 'ulama' al-Mustansiriyya* (Cairo: Dar al-shaʿb, 1976), 2: 69-118.

³⁸⁶ Dhahabi, *Tadhkirat al-hufaz*, 2:284; IF 4:??, Maʿrūf, 1:59ff.

³⁸⁷ Taqi al-Din al-Maqrizi, *Al-Mawaʿiz waʾl-iʿtibar bi-dhikr al-khitat waʾl-athar fi misr waʾl-qahira*, ed. Ayman Fuʾād Sayyid (London: Muʾassasat al-Furqān lil-Turāth al-Islāmī, 200-2003), 2:220.

байлаа” хэмээсэн гэдэг.³⁸⁸ Тэд эндээс ховор номоо хуулуулж авч байсан байна.³⁸⁹

Үүний зэрэгцээ шинэ, хуучин *мадраса* болгонд хувийн хандиваар санхүүждэг номын сан, номын санч ажиллаж байжээ. Энэ хандивын тогтолцоог алдагдуулахгүй байх, Багдад хотын эрдэмтэн мэргэдийн цалинг олгож байх монголчуудын шийдвэр номын санч хийгээд номын сангийн үйл ажиллагааг дэмжин оюуны эрхмүүдтэй хамтран ажиллах бололцоог нээж байжээ.

Эрдэмтдийн болон наймаачдын наад захын хувийн 9 номын сан байсан мэдээ байна. Эдгээрийн ихэнх нь хэдэн мянган номтой байсан гэж үздэг. Этан Колбергийн (Ethan Kohlberg) нарийвчлан судалснаар хамгийн шилдэг жишээ бол Багдад хотын *шиа*-чуудын тэргүүлэгч Ибн Тавусын номын сан юм. Тэр бээр өөрийн хүмүүст өршөөлийн бичгийг худалдаж авсан юм. Түүний номын сангийн бүртгэл олдсон ба маш өргөн сэдвийг хамарсан 660 нэр бүхий гарчиг байна, үүнд Кораны тайлбар, уламжлал, түүх, шашин судлал, одон орон судлал, угийн бичиг болно. Ихэнх нь өнөө устаж үгүй болсон байна. Ибн Тавус номоо гэр бүлдээ өвлүүлжээ. Гэхдээ бусад номын цуглуулагчид номын сангаа өөрсдийн мэргэжил нэгт хүмүүст хишиг болгон өгдөг байжээ.³⁹⁰

Номын худалдаа эрүүл зах зээлийн нөхцөлд үнэтэй бараа болдог бөгөөд номын цуглуулагчид ховор номыг өндөр үнээр авах, тэднийг олохын тулд холын аян замд гарахад бэлэн байв. (Дамаск хотод очих нь их байжээ). Багдад хот ном хэвлэлээрээ алдартай бөгөөд цаас бэлтгэхээс гар бичмэлийн эцсийн шат хүртэлх бүх ажиллагаа, хуулбарлах, чимэг зураг хийх, ном бичих, наймаалах ажлаар олон хүн амьдралаа залгуулдаг байжээ. Хөрш зэргэлдээ улс оронд Багдадын бүтээгдэхүүн их эрэлттэй байв: Йемены Расулын удмын султан Яагуг ал-Мустасимигийн *Kitab al-Aghani* (Дуун ухааны

³⁸⁸ Ibn al-Fuwat, *Talkhis*, 4: 127-8.

³⁸⁹ Ma'ruf, *Mustansiriyya*, 178; Eche 175.

³⁹⁰ . E Kohlberg, *A Medieval Muslim Scholar at Work: The Library of Ibn Tawus* (Brill, 1992); Kutubi, *Fawat*, 2:264.

судар)-ын хувийг 5000 дирхам (ердийн албан хаагчийн жилийн орлогоос хавьгүй их мөнгө) төлсөн байдаг.³⁹¹

Эдгээр дүр зураг монголчуудын үеийн Багдад хотын уналттай хэрхэн зохицож байна? Үгүй л байгаа биз дээ. Тухайн үеийн сурвалжуудад (байлдан дагуулын улс төрийн хийгээд биет гэмтлийг эс тооцвоос) Багдадын соёлын гэмтлийн талаар тун цөөн тохиох бөгөөд энэ маягийн мэдээ ихэнхдээ XIV зууны хоёрдугаар хагаст гарч ирдэг. Энэ үед Ибн ал-Катир, ал-Субки зэрэг Мамлюкийн Султант улсын түүхчдийн дэлхийн төгсгөлийг зөгнөсөн аяс бүхий Багдадын сүйрлийн тухай бичиж, өргөнөөр эшлэгддэг бүтээл гарсан юм. Магадгүй энэ үед Ил-хаант улс задран, мамлюкуудын гол дайсан үгүй болсон учраас тэд Багдадын уналтыг хэтрүүлэх, үүгээрээ 1260 онд монголчуудтай мамлюкууд тулалдсан Айн Жалутын ялалтыг өргөх зорилготой байсан байх. Гэхдээ удалгүй их түүхч Ибн Халдун (1406 онд нас барсан) Багдадын уналтын тухай харамсан бичсэн боловч энэ түүхэн үйл явцаар мамлюк түрэгчүүд гарч ирж Аббасын Халифт улсыг сэргээн, исламыг монголчууд болон франкуудаас аврах зам байсныг олж бичжээ.³⁹²

Түрэг-персийн дундад хийгээд орчин цагийн эхэн үеийн түүхэн дэхил-хаадын Багдадын дүрслэл илүү нааштай хандлагатай: Сафавын болон Османы үед Ил-хаант улсыг “авьяаслаг хүмүүсээр” нь илүү дурддаг байна. Сафавын үеийн түүхч Хондемир (Khwandamir) Аббасын Халифт улсын төгсгөлийг сүүлийн халифын үхлээр бус Хүлэгүгийн мандалтаар (*nahdat-i Hülegü*) дүрсэлжээ. Ингэхдээ Ил-хаант улсын мэргэд, Яагут, Урмави зэрэг Багдадын эрдэмтдийг оролцуулан магтан дуулсан байна.³⁹³ Хүлэгү эрдэмтдийг ивээн

³⁹¹ Khalil ibn Aybak al-Safadi, *A`yan al-`asr wa-a`wan al-nasr*, ed. `A. Abu Zayd et al. (Beirut: Dar al-fikr al-mu`asir and Damascus: Dar al-fikr, 1998), 2:351-3.

³⁹² Ibn Khaldun, *Kitab al-`ibar* (Cairo: al-Maṭba`a al-Miṣriyya bi-Būlāqī, 1967), 3:1106-7; мөн А. Pistor-Hatam, ‘Ursachenforschung und Sinnggebung. Die mongolische Eroberung Bagdads in Ibn Ḥaldūns zyklischem Geschichtsmodell’, in *Die Mamlūken. Studien zu ihrer Geschichte und Kultur. Zum Gedenken an Ulrich Haarmann (1942–1999)*, edited by S. Conermann and A. Pistor-Hatam (Hamburg: EB-Verlag, 2003): 313-34.

³⁹³ Khwandamīr, *Habīb al-siyar* (Tehran: Chapkhanah-i Haydari, 1333/1955), 2:338-41.

тэтгэсэн явдал Османы түүхч Мохаммад Али Пашаг хуульчлан соёрхоход нөлөөлжээ.³⁹⁴ Түүхийг эргэн харахад монголчуудын түрэмгийллийн хэрцгий байдал нь ил-хаадын ухаант удирдлага, соёлын сүр жавхаагаар бүрэн солигдох ба Аббасын халифын үе төгсгөл болсноор Сафавын болон Османы төр барих хууль эрх зүй нээгдсэн юм.

Дүгнэн хэлэхэд, Аббасын Халиф хийгээд арабын эрх мэдэл (түрэг-монголын эрх мэдлийн эсрэг тавихад) 1258 онд төгсгөл болоход Багдад хот хийгээд Исламын соёл иргэншил аль аль нь эрч хүчээ алдаагүй болно. Харин ч Аббасынхны соёлыг устгахын оронд монголчууд тэдний өвийг залгамжлуулан үр ашгийг хүртээхийн ялдамд хаадын сүр хүчний дор шашны амьдралыг тайван үргэлжлүүлэх бололцоо олгожээ. Түүхийг эргэн харахад, ялангуяа ил-хаад исламд орсноос хойш, байлдан дагууллыг бурханы цээрлэл хэмээн хүлээн авч, түрэг-монголын хийгээд араб ертөнцийн ихэнх хэсэгт XIX- XX зууны эхэнд үндсэрхэг үзэл сэргэх хүртэл үүнийг ийнхүү дүгнэх болсон байна.

³⁹⁴ C. H. Fleischer, *Bureaucrat and Intellectual in the Ottoman Empire: The Historian Mustafa Ali (1541-1600)* (Princeton: Princeton University Press, 1986): 283-4.

Ном зүй

- Abū Shāma. *Tarajim rijal al-qarnayn al-sadis wa al-sabi' al-ma'ruf bil-dhail 'ala al-rawḍatayn*. ed. M. Kawtharī (Cairo: Maktab nashr al-thaqafa al-islamiyya. 1947).
- Ahmad Manṣūr. *Qissat suqūf Baghdād*. (Beirut: al-Dār al-‘Arabīyah li’l-‘Ulūm : Dār Ibn Ḥazm. 2003).
- Amitai, Reuven. “Im Westen nicht Neues? Re-examining Hülegü’s offensive into the Jazira and Northern Syria in Light of Recent Research.” in *Historicizing the Beyond: The Mongolian Invasion as a New Dimension of Violence?*. ed. F. Krämer. K. Schmidt and J. Singer (Heidelberg: Universitätsverlag Winter. 2011): 83-96.
- Amitai-Preiss, R. *Mongols and Mamluks: The Mamluk–Īlkhānid War. 1260–1281* (Cambridge. UK; New York: Cambridge University Press. 1995).
- Anon. (Pseudo Ibn al-Fuwati). *Kitab al-Ḥawadith* (Beirut: Dar al-Gharb al-Islami. 1997).
- Anon [Pseudo Qutb al-Din Shirazi]. *Akhhbār-i Mughūlān* (Qum: Kitabkhanah-i buzurg-i hazrat-i ayatallah al-‘uzma Mar‘ashi Najafi. 2010).
- Bar Hebraeus. *The Chronography of Gregory Abu’l-Faraj*. . .commonly known as *Bar Hebraeus*. translated by E. A. W. Budge (Rpt. London: The Georgian Press. 2003).
- Bar Hebraeus. Chronography- Ibn al-`Ibri. *Tarikh Muhtasar al-Duwal* (Beirut: Dar al-Mashriq. 1992).
- Biran, M. “Music in the Conquest of Baghdad: Safi al-Din Urmawi and the Ilkhanid Circle of Musicians.” in *The Mongols and the Transformation of the Middle East*. ed. De Nicola. Bruno and Charles Mellvile (Leiden: E.J. Brill. 2016). 131-154;
- Blake, Robert P. and Frye, Richard N. *History of the Nation of the Archers (The Mongols) by Grigor of Akanc’ энд Małak’ia The Monk: The Armenian Text Edited with an English Translation and Notes.*”*Harvard Journal of Asiatic Studies*. 12 (1949): 345.

- Boyle, John Andrew. "The Death of the Last 'Abbasid Caliph: A Contemporary Muslim Account." *Journal of Semitic Studies* 6 (1961): 160.
- Boyle, John Andrew. "The Longer Introduction to the Zij-i Ilkhani of Nasir ad-Din Tusi." *Journal of Semitic Studies* 8 (1963): 246-247.
- Brinner, W. 'Some *Ayyūbid and Mamlūk Documents* from Non-archival Sources'. *Israel Oriental Studies* 2 (1972): 127-36.
- Canby, Sheila R. "Yākūt al-Mustaʿsimī." *Encyclopaedia of Islam. Second Edition*. EI 2 Online.
- Conermann. 'Die Einnahme Bagdads durch die Mongolen im Jahre 1258: Zerstörung – Rezeption – Wiederaufbau'. in *Städte aus Trümmern. Katastrophenbewältigung zwischen Antike und Moderne*. eds A. Ranft and A. Selzer (Göttingen: Vandenhoeck & Ruprecht. 2004):54-100.
- DeWeese, Devin. "Cultural Transmission and Exchange in the Mongol Empire: Notes from the Biographical Dictionary of Ibn al-Fuwaṣī." in *Beyond the Legacy of Genghis Khan*. ed. Linda Komaroff (Leiden: Brill. 2006): 11-29.
- Fleischer, C. H. *Bureaucrat and Intellectual in the Ottoman Empire: The Historian Mustafa Ali (1541-1600)* (Princeton: Princeton University Press. 1986): 283-284.
- Gilli-Ellevy. "Al-Ḥawadit al-gāmi'a: A Contemporary Account of the Mongol Conquest of Baghdad. 656/1258." *Arabica* 58 (2011): 367.
- Hamdallah Mustawfī. *Nuzhat al-qulūb*. edited and translated Guy le Strange. (Leiden: Brill and London: Luzac. 1915. 1919).
- Ibn al-Fuwati. *Talkhis majma` al-udaba* (Tehran: Mu'asasat al-tibā'a wa-l-nashr. 1995).
- Ibn Battuta. *The Travels of Ibn Battuta*. tr. H. A. R. Gibb (Cambridge: The Hakluyt Society. 1958). 2: 342-344.
- Ibn Kathir. *al-Bidaya wa-l-nihaya* (Beirut: Dar ihya' al-turath al-'arabi. 1993).
- Ibn Khaldun. *Kitab al-'ibar* (Cairo: al-Maṭba'a al-Miṣriyya bi-Būlāqī. 1967). 3:1106-7.

- Kāzarūnī. *Mukhtaṣar al-ta`rīkh. min awwal al-zamān ilā muntahā dawlat Banī al-`Abbās* (Baghdad: Mudiriyat al-thaqafa al-`amma. 1970).
- Khalil ibn Aybak al-Safadi. *A`yan al-`asr wa-a`wan al-nasr*. ed. `A. Abu Zayd et al. (Beirut: Dar al-fikr al-mu`asir and Damascus: Dar al-fikr. 1998). 2:351-3.
- Krämer, F. 'The Fall of Baghdad in 1258: The Mongol Conquest and Warfare as an Example of Violence'. in *Historicizing the "Beyond": The Mongolian Invasion as a New Dimension of Violence?*. edited by F. Krämer. K. Schmidt and J. Singer (Heidelberg: Universitätsverlag WINTER. 2011): 97-116.
- Kohlberg, E. *A Medieval Muslim Scholar at Work: The Library of Ibn Tawus* (Brill. 1992); Kutubi. *Fawat*. 2:264
- Khwandamīr. *Habīb al-siyar* (Tehran: Chapkhanah-i Haydari. 1333/1955). 2:338-41.
- Lewis, Bernard. "The Mongols, the Turks and Muslim Polity." *Transactions of the Royal Historical Society*. Fifth Series. Vol. 18 (1968): 49.
- Mellville, Charles P. "The Itineraries of Sultan *Oljeitu*. 1304–16." *Iran* 28 (1990): 55–70.
- Meyvaert, P. "An Unknown Letter of Hulagu, Il-Khan of Persia, to King Louis IX of France." *Viator* 11 (1980): 245-59.
- Muhammad b. Shakir al-Kutubi. *Fawat al-wafayat* (Beirut: Dar al-kutub al-`ilmiyya. 2000).
- Neggaz, Nassima. "The Falls of Baghdad In 1258 And 2003: A Study In Sunnī-Shī`ī Clashing Memories" (PhD diss. Georgetown University. 2013).
- Pistor-Hatam, A. "Ursachenforschung und Sinngebung. Die mongolische Eroberung Bagdads in Ibn Ḥaldūns zyklischem Geschichtsmodell." in *Die Mamlūken. Studien zu ihrer Geschichte und Kultur. Zum Gedenken an Ulrich Haarmann (1942–1999)*. edited by S. Conermann and A. Pistor-Hatam (Hamburg: EB-Verlag. 2003): 313-34.

- Polk, W. R. *Understanding Iraq: The Whole Sweep of Iraqi History. from Genghis Khan's Mongols to the Ottoman Turks to the British Mandate to the American Occupation* (New York: HarperCollins. 2005).
- Raghib al-Sargānī. *Qiṣṣat al-Tatār* (Cairo: Mu'asasat Iqra'. 2006).
- Rashid al-Din. *Jami` al-tawarikh*. ed. B. Karimi (Tehran: Iqbāl. 1338/1960). 2: 713;
- Rashid Wu Painan. "The fall of Baghdad and the Mongol rule in al-Īrāq. 1258-1335." (Phd diss.. University of Utah. 1974).
- Shams al-Din Muhammad b. Ahmad al-Dhahabi. *Ta'rikh al-Islam* (Beirut: Dar al-kitab al-'arabi. 2003).
- Shihab al-Din Aḥmad b. `Abd al-Wahhab al-Nuwayri. *Nihayat al-arab fi funūn al-adab* (Cairo: al-Hay'a al-Miṣriyya al-`amma li'l-Kitab. 1984). 23: 234;
- Shihab al-Din al-`Umari. *Masalik al-absar wa-mamalik al-amsar* (Beirut: Dar al-kutub al`Imiyya. 2010). 10: 353-356.
- Taqī al-Din al-Maqrizi. *Al-Mawa`iz wa'l-i`tibar bi-dhikr al-khitat wa'l-athar fi misr wa'l-qahira*. ed. Ayman Fu'ād Sayyid (London: Mu'assasat al-Furqān lil-Turāth al-Islāmī. 200-2003). 2:220.
- Thackston, Wheeler M. trans.. *Jami`u't-tawarikh [sic] Compendium of Chronicles* (Cambridge MA: Department of Near Eastern Languages and Civilizations. Harvard University. 1998-1999). 3: 498;
- Umari. *Masalik*. ed. and trans. K. Lech as *Das Mongolische Weltreich: al-Umari's Darstellung der mongolischen Reiche in seinem Werk Masalik al-absar fi mamalik al-amsar*. Asiatische Forschungen. vol. 14. (Wiesbaden. 1968).
- Vladimir Minorsky. trans. *Calligraphers and Painters. A Treatise by Qādī Aḥmad. son of Mīr-Munshī. circa A.H. 1015/A.D. 1606*. (Washington: The Smithsonian Institution. 1959).
- Waṣṣaf. *Ta'rikh-i Wassaf (Tajziyat al-amsar wa-tazjiyat al-a'mar)*. Bombay. 1269/1852–1853 (rpt. Tehran. 1338/1959–1960). 43; and `A. M. Ayati. *Taḥrīr-i ta'rikh-i Wassaf* (Tehran: Chāpkhānah-i `ilmī. 1346/1967). 23.